



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/ЗЧД

Арвайхээр сум

Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг
зохион байгуулж явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.10, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрийн Батлан хамгаалах зарим чиг үүргийг Өвөрхангай аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээнд заасны дагуу Аймгийн Засаг даргын нэрэмжит, аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд Арвайхээр суманд зохион байгуулж явуулсугай.

2. Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, тэмцээнийг шүүх шүүгчдийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, шаардагдах зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг зохион байгуулж явуулахад шаардагдах 4,249,100 (дөрвөн сая хоёр зуун дөчин есөн мянга нэг зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний бэлтгэл болон зохион байгуулах үеийн арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Ажлын хэсэг (дэд хурандаа А.Нямхүү)-т, батлагдсан удирдамж, заавар, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, хөдөлгөөний үеийн аюулгүй ажиллагааны болон бусад холбогдох дүрэм, журмыг сайтар мөрдүүлж ажиллахыг сумдын Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

5. Тэмцээнийг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулж, дүнг илтгэхийг Цэргийн штабын дарга, ажлын хэсгийн ахлагч (дэд хурандаа А.Нямхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224-11 0706

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дүгээр
сарын 01-ний өдрийн 4012 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ, АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ, ЗОХИОН
БАЙГУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: А.Нямхүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб дарга, дэд хурандаа)

Гишүүдэд: М.Дэлгэрсайхан (Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч, хурандаа)

Б.Галбат (Зэвсэгт хүчний 113 дугаар тусгай) салбарын захирагч, хошууч)

Д.Одонбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа)

Г.Чимэддагва (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газрын дарга цагдаагийн хурандаа)

Г.Пүрэвдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Д.Өсөх-эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ө.Жандүдсансүм (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Биеийн тамир спортын газрын дарга)

Г.Дашжанцан (Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн дарга)

Н.Цэвээндулам (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дүгээр
сарын 01 -ний өдрийн 113 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ, АЙМГИЙН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР
ТЭМЦЭЭНИЙГ ШҮҮХ ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ерөнхий шүүгч: А.Нямхүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб дарга, дэд хурандаа)

Ерөнхий шүүгчийн туслах, цагийн шүүгч:

Ч.Адъяа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын орон нутгийн хамгаалалтын бэлтгэл, сургалтын офицер, дэд хурандаа)

Б.Гомбосүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын биеийн тамирын боловсрол хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Шүүгчид: Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 256 дугаар анги, 113 дугаар тусгай салбар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Соёл, урлагийн газар, Биеийн тамир спортын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын томилогдсон бүрэлдэхүүн

Нарийн бичгийн дарга: Ч.Ванчинсүрэн (аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэлийн ахлах офицер, дэд хурандаа)

-оОо-

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар
сарын 01 -ний өдрийн 13/31 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ, АЙМГИЙН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНД
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Хийгдэх арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Нийт дүн (төг)	Тайлбар
1	Тэмцээний эхний 3 байр, тусгай байр эзэлсэн тасагт “Өргөмжлөл” хийлгэх	4ш	60,000	240,000	
2	Тэргүүн байр эзэлсэн тасагт олгох цом хийлгэх	1ш	150,000	150,000	
3	Тэмцээний эхний 3 байр эзэлсэн тасагт медаль хийлгэх	45ш	8,000	360,000	
4	“Дөл” тэмцээний мөнгөн шагнал	I байр II байр III байр	1,000,000 800,000 600,000	2,400,000	
5	Шүүгчдийн өдрийн хоол	15 хүн	15,000	225,000	
6	Шүүгчдийг тээвэрлэх авто машины шатахууны зардал	30 л (бинзен)	2470	74,100	
7	Эхний 3 байр, тусгай байр эзэлсэн сургуулийн захиралд өгөх “Өргөмжлөл”, дурсгалын зураг	4ш	50,000	200,000	
8	Тэмцээний оролцогч бүрт олгох “Дурсамж” хэвлүүлэх	300ш	2,000	600,000	
Нийт дүн				4,249,100	